заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгож, хуулийн 29.3 дахь хэсэгт заасныг үндэслэн удаахь хамгийн сайн үнэлэгдсэн тендер шрүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**38. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

38.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдлийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө шалгарсан тендерт оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

38.2. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг мэдэгдсэнээс хойш ажлын 6 хоногийн дотор гэрээг баталгаажуулж гарын үсэг зурахыг хориглоно. Энэ заалтыг зөрчиж байгуулсан гэрээ нь хуулийн 42.1.2-т зааснаар хүчин төгөлдөр бус гэрээ гэж тооцох үндэслэл болно.

38.3. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь гэрээ байгуулах үндэслэл болно. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл гаргаснаар тендерт оролцогч 40 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, 39 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурах хүртэл захиалагч гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогч нарын хооронд хэлцэл хийгдсэн гэж үзнэ.

38.4. Захиалагч нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) вэб сайтад тендерийн нэр болон багцийн дугаарыг дараах мэдээллийн хамтаар нийтэлнэ:

- 1) Тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
- 2) Тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
- 3) Нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
- 4) Тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
- 5) Тендерт шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон үнэ, түүнчлэн батлагдсан гэрээний дүн.

38.5. Гэрээ байгуулсан тухай мэдээлсний дараагаар, шалгараагүй тендерт оролцогч тендерийг нь татгалзсан үндэслэл, шалтгааны талаар тайлбар ирүүлэх хүсэлтийг бичгээр гаргаж болно. Ийм хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.

38.6. Шалгарсан тендерт оролцогч ТООЗ-ын 40 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, гэрээнд гарын үсэг зурсны дараагаар захиалагч ТООЗ-ын 21.8-д заасан хугацаанд тендерийн баталгааг цуцлах талаар бусад тендерт оролцогч нарт мэдэгдэнэ.

**39. Гэрээнд гарын үсэг зурах**

39.1. Захиалагч нь гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлүүдийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт

оролцогчид илгээнэ.

39.2. Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний маягыг хүлээн авснаас хойш ажлын 6-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хоногийн дотор түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

39.3. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн даруй гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

**40. Гүйцэтгэлийн баталгаа**

40.1. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас гэрээний тусгай нөхцөлд заасан дүнгээр, ТШӨХ-д заасан маягтаар болон гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид ирүүлнэ.

40.2. Гүйцэтгэлийн баталгааг:

(а) тендерт оролцогчийн сонголтоор Монгол улсад байрладаг банкаар буюу гадаадын банкны Монгол улсад байрладаг харилцагч банкаар,

эсхүл

(б) захиалагчийн хүлээн зөвшөөрсөн гадаадын банкаар гаргуулна.

40.3. Шалгарсан тендерт оролцогч ТӨӨЗ-ны 40.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох, тендерийн баталгааг гүйцэтгүүлэх хангалттай үндэслэл болно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь ТООЗ-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. **Хэрэв ТООЗ-ны зүйл заалттай зөрчилдвөл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.**

ТООЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТООЗ 1.1	Захиалагч нь: <b>[Төв аймаг Газрын харилцаа, Барилга, Хот байгуулалтын ажил]</b>
ТООЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: <b>[ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН БАРИЛГЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ]</b> <b>ТШДугаар: ТӨАОНӨГ/202004091</b>
ТООЗ 1.2	Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь: <b>[2020 оны 08 дугаар сарын 01-ны өдөр]</b> Тендерт оролцогч нь зураг төсвөөр тодорхойлсон ажил-өдрийн тоо хэмжээ түүнийг гүйцэтгэх эцсийн хугацаанд нийцсэн барилга угсралтын ажлын үе шатны хуваарийг заасан Маягт №ТШМ-2-2.6 хүснэгтээр гарган баталгаажуулж ирүүлэх бөгөөд захиалагчаас санал болгож буй ажил-өдрийн тоо болон ажил гүйцэтгэж дуусах эцсийн хугацаанд нийцээгүй мөн үе шатны ажлын хуваарьт зардал тус бүрийн үнийг бичиж, арифметик алдаатай ирүүлсэн үе шатны хуваарь бүхий оролцогчийн тендерээс татгалзана. Үе шатны ажлын хуваарь боловсруулах хүснэгт Маягт № ТШМ-2-2.6-г тендерийн баримт бичигт хавсаргав.
ТООЗ 1.3	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>[багцгүй]</b>
ТООЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>[Олон улсын байгууллага, Аймгийн орон нутгийн хөгжлийн сан]</b> <b>Нийт төсөв: 1 196 000 000 төгрөг.</b> <b>Орон нутгийн оролцооны санхүүжигдэх дүн: : 276 000 000 төгрөг</b> <b>Олон улсын байгууллагаас санхүүжигдэх дүн: 920 000 000 төгрөг</b> <b>2020 онд санхүүжүүлэх нь: 1 196 000 000 төгрөг.</b>

**ТӨӨЗ 4.4.(в)**

Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: **["тийм"] "Дунд төвөгшилтэй барилга байгууламж"**

-БА-3.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил

-БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

-БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

-БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

-БА-6.4 Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

-БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил

/Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна./ Тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны "Аргачлал батлах тухай" 33 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу дүйцүүлж үзнэ.



**ТӨӨЗ 5.2 (а)**

Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх:

1.1 Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

1.2 Тусгай зөвшөөрөл болон түүний гэрээ, хавсралтын хуулбар /нотариатаар баталгаажуулсан байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь "Тусгай зөвшөөрөл олгох асуудал хариуцагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын хооронд байгуулсан гэрээний 3.2-т заасан үүргээ биелүүлсэн байна/,

1.3 Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байх бөгөөд зөвхөн Татварын ерөнхий газрын [www.e-tax.mta.mn](http://www.e-tax.mta.mn) сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна.

1.4 Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Харьяа Нийгмийн даатгалын санд өр төлбөргүй тодорхойлолт ирүүлнэ. Тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна,

1.5 Компани, мөн үүсгэн байгуулагчид, гүйцэтгэх удирдлагын сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээллийг Шүүхийн төрөлжсөн архив, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тодорхойлолт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт.

1.6 Компани, түүний хувьцаа эзэмшигч нь хугацаа хэтэрсэн болон зээлийн батлан даалтын гэрээгээр хүлээсэн өр төлбөргүй тухай харилцах банкны тодорхойлолт, /тодорхойлолтыг компани болон захирал, ТУЗ-ийн гишүүдээр авч тендерт ирүүлнэ./

1.7 Улсын бүртгэлийн гэрчилгээн дээр бүртгэгдсэн харилцагч банк болгоноос хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өртэй эсэх тодорхойлолтыг авч ирүүлнэ.

1.8 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, банк болон дээрх бусад холбогдох байгууллагаас тендерийн бичиг баримттай холбоотой асуудлаар болон нэмэлт тодорхойлолт, лавлагаа гаргуулахад тендерт оролцогч татгалзах зүйлгүй гэсэн мэдэгдлийг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ.

1.9 Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн *итгэмжлэлийг маягт №ТШМ-2-2* дагуу гаргаж ирүүлнэ. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тендерт оролцогчийн үндсэн ажилтан байж, түүнийг ажилд томилсон анхны тушаал, иргэний үнэмлэхийг нотариотаар батлуулсан хуулбар, харилцагч байгууллага, эрх бүхий байгууллагуудаас өр, төлбөргүй талаарх албан ёсны тодорхойлолт ирүүлнэ.

Дээрх тодорхойлолтууд нь тендер зарлагдсан өдрөөс хойш авсан, зөвхөн захиалагчид хаяглагдсан байна. Тодорхойлолтуудыг эрх бүхий байгууллагаас олгосноос хойш сарын хугацаанд хүчинтэй гэж үзнэ. Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно.

1.10 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана./

1.11 Сүүлийн 3 жил /2017, 2018, 2019 он/-д нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээ чанартай, холбогдох стандартыг хангаж байгаа талаар өмнөх захиалагч байгууллагуудын тодорхойлолт, гэрээ дүгнэсэн актыг ирүүлнэ. Өмнөх үйлчлүүлэгч, захиалагчтай холбогдох утас, мэйл хаягийг жагсаалтаар ирүүлсэн байна./

1.12 Байгууллага, аж ахуйн нэгжийн талаархи мэдээллийг №ТШМ-2-3 маягтын дагуу ирүүлэх.

1.13 Тендерт оролцогч олон багц ажлын тендерт оролцох болон хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл, тус гэрээнд ажиллаж байгаа, ажиллуулах голлох инженер, техникийн ажилтан, ажилчид, машин механизм, багаж хэрэгсэл нь 1 хүртэл багцад давхцан ажиллах боломжтой бөгөөд тендерт санал болгосон голлох инженер, техникийн ажилтан, ажилчид, машин механизм, багаж хэрэгсэл нь 1-ээс дээш багц ажил /хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан тендерт шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх авах тендерийн багц хамаарна/-д давхардсан тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. /2019 онд эрх авсан ажил он дамжиж хэрэгжиж байгаа бол ТШӨХ-н ТООЗ-ны 5.3 (б)-д заасан ажлын гүйцэтгэл 70 хувь буюу түүнээс дээш гүйцэтгэлтэй байна/

1.14 Тендерт оролцогч нь дээрх 1.13-т заасан гэрээ хэрэгжүүлж байгаа болон гэрээ байгуулах эрх авсан талаарх мэдээлэл, мэдэгдлийг албан бичгээр гаргаж ирүүлнэ.

1.15 Тендерт оролцогч нь Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолд тусгагдсан “Дотоодод үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан бараа”-ны жагсаалтад тусгагдсан барааг барилгын ажилд ашиглах бол тухайн барааны нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртөг, барааны гарал үүслийн талаарх мэдээллийг, дотоодод үйлдвэрлэгдсэн бараа, бүтээгдэхүүн ашиглахгүй бол тэр талаарх мэдэгдэлийг тус тус ирүүлнэ.

1.16 Тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолгүй тухай мэдэгдэл ирүүлнэ.

1.17 ТШӨХ-н ТООЗ 5.2-т заасан өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй эсхүл дээр заасан тодорхойлолтууд, баримт бичгүүдээс ирүүлээгүй, ирүүлсэн баримт бичиг нь захиалагчид хаяглагдаагүй, заасан нөхцөл, шалгуурыг хангахгүй, хуурамч, эсхүл сүүлийн 3 жилд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний чанар хангалтгүй байсан нь өмнөх захиалагч байгууллагуудын тодорхойлолтоор болон хяналт шалгалтын байгууллагын хяналтаар нотлогдсон зэрэг тохиолдолд тендерээс татгалзаж, хуурамч нотлох баримт ирүүлсэн нь нотлогдсон нөхцөлд тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгүүлэхээр эрх бүхий байгууллагад хандана.

**Анхааруулга:** УИХ-ын 2019.03.22-ны өдрийн чуулганаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль 2019.06.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөх бөгөөд уг хуулийн 55 дугаар зүйлийн 55.9-д “Тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ хуулийн 20.7.3-т заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээг 20 сая төгрөгөөс хэтрэхгүй. Гомдлыг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг буцаан олгоно” гэж заасан. Сангийн яаманд гаргасан гомдол “үндэслэлгүй” гэж шийдвэрлэгдсэн тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгох эрх зүйн зохицуулалт 2019.06.01-ний өдрөөс үйлчилж эхэлсэн болохыг анхааруулъя,

**ТӨӨЗ 5.2.(б)**

Санхүүгийн тайланг ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн [www.e-balance.mof.gov.mn](http://www.e-balance.mof.gov.mn)-ээс тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.

**Санхүүгийн чадавхийн талаарх мэдээллийг маягт №ТШМ-2-4 дагуу 2017, 2018, 2019 онуудыг тооцож ирүүлнэ.**

**2017, 2018, 2019 оны санхүүгийн тайлан сангийн яамны e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайлан бүртгэлд шивэгдээгүй дээрх нөхцөлийг хангаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.**

**ТӨӨЗ 5.2.(в)**

Голлох болон инженер техникийн ажилтнууд дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд: **№ТШМ-2-1.5**

Санал болгож буй мэргэжилтний овог, нэр	Хүний тоо	Албан тушаал	Мэргэжил	Ажлын туршлага
Байгууллагын үндсэн ажилчид байна.	1	Ерөнхий инженер	Барилгын инженер	5 жилээс дээш
	1	Барилгын даамал	Барилгын инженер, барилгын техникч	3 жилээс дээш
	1	Цахилгааны инженер	Цахилгааны инженер	3 жилээс дээш
	1	Холбоо дохиолол, мэдээллийн технологийн инженер	Холбоо дохиолол, мэдээллийн технологийн инженер	3 жилээс дээш
	1	Ус хангамж, ариутгалын татуургын инженер	Ус хангамж, ариутгах татуургын инженер /Сантехникийн инженер/	3 жилээс дээш
	1	Халаалт, агаар сэлгэлтийн инженер	Халаалт, агаар сэлгэлтийн инженер /Дулааны ижнер/	3 жилээс дээш
	1	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан /инженер/	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны гэрчилгээтэй байх/	1 жилээс дээш
	1	Интерьер дизайнер	Архитектор /Компьютер график/	3 жилээс дээш

: **№ТШМ-2-1.6**

Санал болгож буй мэргэжилтний овог, нэр	Хүний тоо	Албан тушаал	Мэргэжил	Ажлын туршлага
Ажилчид байна	20	барилгын мэргэжилтэй ажилчид	-	-
	-	-	-	-

1. №ТШМ-2-1.5 хүснэгтэд заасан голлох инженер, техникийн ажилтан, ажилчдын 50 хувиас доошгүй нь тендерт оролцогчийн үндсэн ажилчид байна. Үүнийг нотолж №ТШМ-2-1.5 хүснэгтэд заасан инженер, техникийн ажилчдын нэрийн дагуу 2019 оны 10-12 дугаар, 2020 оны 1-4 дугаар саруудын нийгмийн даатгалын шимтгэлийг тасралтгүй төлсөн НД7, НД8 тайлан, үндсэн ажилчдын нэрсийн НДШимтгэл төлөлтийн талаарх дээрх хугацааг бүрэн хамарсан түц машины лавлагааг ирүүлэхийн зэрэгцээ Нийгмийн даатгалийн дэвтрийн 1 дүгээр хуудас, дээрх хугацаанд тасралтгүй шимтгэл төлсөн болон “даатгуулагчийн ажил албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл”-ийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж анх ажилд томилсон тушаалын хамт ирүүлнэ.

	<p>2. Хүснэгтэд байгаа инженер, техникийн ажилчин, ажилтнуудын иргэний үнэмлэхний, дипломны, мэргэжлийн үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбарууд, ИТА-ны туршлагын талаархи мэдээллийг тус тус ирүүлэх. /Уг төсөлд санал болгож буй бүх инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилтнууд хамаарна./</p> <p>3. Инженер, техникийн ажилчдын мэргэжлийн үнэмлэх, диплом гадаад хэлээр бол албан ёсны орчуулга хийх эрх бүхий этгээдээр орчуулуулсан байна. ТӨӨЗ-ны 5.2 (в)-ийн 1, 2, 3-т заасан өгөгдөл шаардлага болон инженер, техникийн ажилтан, ажилчдын шаардсан материалуудыг бүрэн ирүүлээгүй тендерээс татгалзана.</p>															
<p><b>ТӨӨЗ 5.2 (г)</b></p>	<p>1. Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудад гүйцэтгэсэн барилга угсралтын ажил, тэдгээрийн гэрээний үнийг жил жилээр харуулсан мэдээллийг ижил төстэй ажилд тооцуулахаар доорх хүснэгтээр ирүүлэх:</p> <table border="1" data-bbox="475 633 1450 813"> <thead> <tr> <th data-bbox="475 633 555 734">№</th> <th data-bbox="555 633 722 734">Гэрээний нэр</th> <th data-bbox="722 633 1106 734">Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс</th> <th data-bbox="1106 633 1233 734">Төсөвт өртөг</th> <th data-bbox="1233 633 1450 734">Дууссан, эсхүл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="475 734 555 768">1</td> <td data-bbox="555 734 722 768"></td> <td data-bbox="722 734 1106 768"></td> <td data-bbox="1106 734 1233 768"></td> <td data-bbox="1233 734 1450 768"></td> </tr> <tr> <td data-bbox="475 768 555 813"></td> <td data-bbox="555 768 722 813">Дүн</td> <td data-bbox="722 768 1106 813"></td> <td data-bbox="1106 768 1233 813"></td> <td data-bbox="1233 768 1450 813"></td> </tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөвт өртөг	Дууссан, эсхүл дуусах хугацаа	1						Дүн			
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөвт өртөг	Дууссан, эсхүл дуусах хугацаа												
1																
	Дүн															
<p><b>ТӨӨЗ 5.2 (д)</b></p>	<p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх:</p> <p>1. Сүүлийн 3 /2017, 2018, 2019 он/ хугацаанд доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй барилга угсралтын ажилтай ижил төстэй ажлыг гүйцэтгэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх ба энэхүү гэрээ (ижил төстэй ажил /интерьер засвар шинэчлэлийн ажил/-ыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн тэр гэрээ)-ний үнэ нь энэ тендерт санал болгож буй ажлын төсөвт өртгийн 40 хувиас багагүй байж, нотлох баримтыг ирүүлнэ.</p> <p>2. Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудад гэрээгээр гүйцэтгэсэн барилга угсралтын ажлыг ижил төстэй ажилд тооцуулах ажлын жагсаалт, ажил тус бүрийн гэрээний эх хувиас татсан хуулбар, гэрээ дүгнэсэн акт, гэрээ бүрийн гүйцэтгэл бүрэн, чанартай байсан талаар өмнөх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлэх, ажлыг ашиглалтад оруулах Улсын комиссын акт зэрэг баримт бичгийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж, PDF хэлбэрт шилжүүлэн ирүүлнэ. Барилга байгууламжийн ажлын захиалагч нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгүүлсэн бол захиалагч байгууллагаар томилогдсон байгууллага эсхүл аймаг, сумын Засаг даргын тамгын газраас олгосон тодорхойлолтын аль нэгийг, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэсэн тохиолдолд захиалагч байгууллагын тодорхойлолтыг, хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн тохиолдолд үндсэн захиалагч байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>3. Ижил төстэй ажилд интерьер засвар шинэчлэлийн ажлыг тооцно.</p> <p>ТШӨХ-н ТӨӨЗ 5.2 (д)-н 1, 2, 3-д заасан өгөгдөл, шаардлагад заасан баримт материалуудыг дутуу ирүүлсэн бол тухайн тендерээс татгалзана.</p>															

<p><b>ТӨӨЗ 5.2 (к)</b></p>	<p>Тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хувь хүртэл байна. Үүнээс дээш хувийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх бол түншлэлийн гэрээ байгуулж тендерийн хамт ирүүлэх ба Түншлэгч нь тендерийн баримт бичгийн ТӨӨЗ болон гэрээний тусгай нөхцлийн шалгуурт заасан нөхцөл өгөгдөл тус бүрт заасан үзүүлэлтийг хангасан байх шаардлагатайгаас гадна ТӨӨЗ 5.2-т заасан бүх материалыг бүрдүүлж ирүүлсэн байна.</p> <p><b>Тендерт оролцогч туслан гүйцэтгэгч авах бол тендерт санал болгох бөгөөд туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний эх хувийг наториатаар баталгаажуулан, туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажлын төсвийг БНБД дагуу тооцож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулж ирүүлнэ. Мөн туслан гүйцэтгэгч нь ТӨӨЗ 4.4 (в)-д заасан тусгай зөвшөөрөлтэйг нотлох баримт бичгийн хуулбарыг, улсын бүртгэлийн гэрчилгээтэй хамт ноториатаар баталгаажуулж хавсаргаж ирүүлнэ. /Түншлэгчийн хувьд тендерт оролцогчийн нэгэн ижил нөхцөл, шаардлагыг хангасан байх бөгөөд түншлэгчийн гүйцэтгэх ажлын төсвийг БНБД дагуу тооцож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулж, холбогдох баримт бичгийг ирүүлсэн байна./</b></p> <p>Түншлэгч болон туслан гүйцэтгэгч нь дээрх шаардлагыг хангаагүй мөн төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181-р тушаалаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу алдаагүй тооцож, Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох програмаар алдаагүй хийж гүйцэтгэсэн байх бөгөөд заасан нөхцөл шаардлагыг хангаагүй тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
<p><b>ТӨӨЗ 5.2 (е)</b></p>	<p>/Гэрээт ажилд ашиглах өөрийн эзэмшлийн машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ноториатаар баталгаажуулж ирүүлнэ. Гэрээт ажилд ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалтыг маягт №ТШМ-2-1.4 дагуу ирүүлнэ.</p>
<p><b>ТӨӨЗ 5.2 (з)</b></p>	<p>Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээллийг маягт №ТШМ-2-1.10 дагуу ирүүлнэ.</p>
<p><b>ТӨӨЗ 5.2 (и)</b></p>	<p>Тендерт оролцогч туслан гүйцэтгэгч болон түншлэлээр хамтран тендерт оролцож болно.</p> <p><b>+Тендерт түншлэгчээр оролцогч нь ТШӨХ-ийн ТӨӨЗ-ны 5.2-ын (а)-(и) хүртлэх ирүүлэхээр заасан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн цахим хэлбэрт оруулж ирүүлэх ба ирүүлсэн бүх материалд тод, уншигдахуйц, бичиг хэргийн стандарт шаардлага хангасан байх шаардлагатай.</b></p> <p><b>Хэрэв тод биш, уншигдахааргүй тендерийн материал ирүүлсэн бол иж бүрдэл дутуу гэж үзэн тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</b></p>
<p><b>ТӨӨЗ 5.3 (а)</b></p>	<p><b>Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж нь уг ажлын төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх.</b></p>

**ТӨӨЗ 5.3 (б)**

Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байвал зохих хугацаа:

ТӨӨЗ 5.3 (б)-ын 1. Сүүлийн 3 /2017, 2018, 2019 он/ хугацаанд доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй барилга угсралтын ажилтай ижил төстэй ажлыг гүйцэтгэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх ба энэхүү гэрээ (ижил төстэй ажил /интерьер засвар шинэчлэлийн ажил/-ыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн тэр гэрээ)-ний үнэ нь энэ тендерт санал болгож буй ажлын төсөвт өртгийн 40 хувиас багагүй байж, нотлох баримтыг ирүүлнэ.

Сүүлийн 3 жил /2017, 2018, 2019/-ийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй доод тал нь нэг удаагийн ажил гүйцэтгэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байна. /энэ шаардлагыг хангахын тулд нэрлэсэн тухайн оны, он дамжиж буй ажлуудын доод тал нь 70 хувийг гүйцэтгэсэн байх шаардлагатай бөгөөд Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын Хавсралт №4, Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийн материалын эх хувиас хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ./

2019 онд эрх авч гүйцэтгэсэн ажлын явцын 70 хувийг гүйцэтгэсэн байх -Шаардлага хангасан гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.

-Тухайн онуудад хэрэгжүүлж буй Төслийн талаар Захиалагчаас ажлын явц, гүйцэтгэл 2020.04 сарын байдлаар хэдэн хувьтай байгаа талаарх захиалагчийн тодорхойлолтыг зөвхөн захиалагчид хаяглан фото зургийн хамт ирүүлнэ. Он дамжсан ажил байхгүй бол энэ талаар албан мэдэгдлийг мөн заавал захиалагчид хаяглан ирүүлсэн байна.

**Тендерт оролцогчийн ирүүлсэн тендер нь ТШӨХ-ийн ТӨӨЗ 5.3 (а), ТӨӨЗ 5.3 (б)-д заасан өгөгдөл, шаардлагыг хангаагүй, баримт материалуудыг бүрэн ирүүлээгүй бол уг тендерээс татгалзана,**

**ТӨӨЗ 5.3 (в)**

Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудыг дараах хүснэгтэд зааснаар ирүүлнэ. **Тендерт оролцогч уг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах нийт багаж, техник, тоног төхөөрөмжийг нэг бүрчлэн жагсааж ирүүлсэн байна.** техник Маягт № ТШМ-2-1.4

Машин тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн нэр, зориулалт	Тоо хэмжээ	Улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн паспортыг дугаар	Эзэмшдэг байгууллага иргэний нэр	Чанар байдал, ашиглалт ад орсон огноо
Авто машин 2 тн	1	Тээврийн хэрэгслийн техникийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар ирүүлнэ.	өөрийн өмчлөлд байх бөгөөд бусад хэсэгт нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийнх эсхүл түрээсийн байж болно.	Авто тээврийн хэрэгсэл, машин механизм нь 2020 онд техникийн улсын үзлэг тооллогод орсон байна.
Крантай автомашин	1			
Кран 5 тн-оос дээш	1			
Авто машин 5 тн	1			

**Бусад тоног төхөөрөмж Маягт № ТШМ-2-1.5**

Машин тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн нэр, зориулалт	Тоо хэмжээ	Улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн паспортыг дугаар	Эзэмшдэг байгууллага иргэний нэр	Чанар байдал, ашиглалт ад орсон огноо
Хийн цохилтот нягтруулагч	1	Тээврийн хэрэгслийн техникийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар ирүүлнэ.	өөрийн өмчлөлд байх бөгөөд бусад хэсэгт нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийнх эсхүл түрээсийн байж болно.	Авто тээврийн хэрэгсэл, машин механизм нь 2020 онд техникийн улсын үзлэг тооллогод орсон байна.
Молдок /бутлагч/	2			
Цахилгаан гагнуурын агрегат	1			
Цахилгаан үүсгүүр	1			
Бетон зуурагч	1			
Подём	1			
Угсралтын агрегат	1			
Гагнуурын аппарат	2			
Бусад тоног төхөөрөмж	Тоогоор ирүүлнэ	Төсөвт заасан бусад тоног төхөөрөмж		Зургийг ирүүлнэ.

Маягт № ТШМ-2-1.4 хүснэгт заасан машин механизм, тоног төхөөрөмжийн 50-аас доошгүй хувь нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлд байх бөгөөд бусад хэсэгт нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийнх эсхүл түрээсийн байж болно.



	<p>Түрээсийн машин тоног төхөөрөмжийг ашиглах тохиолдолд машин тоног төхөөрөмж ашиглах түрээсийн гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх бөгөөд гэрээг 2020 онд байгуулсан байна. Машин тоног төхөөрөмж нь тендерт оролцогчийн эсхүл түрээсийн болохыг дараах баримт бичгээр нотлоно. Үүнд:</p> <p>-Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж бүрийн техникийн болон тээврийн хэрэгслийн гэрчилгээний нотариатоор батлуулсан хуулбар түүнд дээр бичигдсэн эзэмшигч ашиглагчийн нэр, 2020 оны техникийн улсын бүртгэл тооллогод орсон тэмдэглэл, баталгаажсан байх.</p> <p>-Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан түрээсийн гэрээ</p> <p>-Хэмжих, хянах багаж хэрэгсэл бүр нь холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон баталгаажилтын гэрчилгээтэй болохыг нотолж гэрчилгээний нотариатоор батлуулсан хуулбар ирүүлнэ. Уг гэрчилгээний баталгаажуулалтын хугацаа хүчинтэй байх шаардлагатай.</p> <p>-ТББичигт авто кран ашиглахаар заасан нөхцөлд <b>Авто кран нь</b> аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тухай мэргэжлийн хяналтын газраас олгосон техникийн дүгнэлт болон техникийн улсын үзлэг тооллогод орсон байх /2019 онд олгосон техникийн дүгнэлтийн хугацаа нь уг ажлын тендерийн хүчинтэй байх хугацаанд хүчинтэй байна, хугацаа дууссан бол 2020 оны мэргэжлийн хяналтын газраас олгосон техникийн дүгнэлт, техникийн улсын үзлэг тооллогод орсон байна./ дээрх материалыг бүрэн ирүүлсэн байна.</p> <p>-Тухайн ажилд санал болгож буй тээврийн хэрэгсэл, машин механизмын талаарх баталгаажсан лавлагааг Авто тээврийн үндэсний төвөөс авч хавсарган ирүүлэх шаардлагатай.</p> <p><i>Дээрхи тоног төхөөрөмж нь тендерт оролцогчийн өөрийн эзэмшлийн өмч хөрөнгө, түрээсийн болох нь тээврийн хэрэгслийн техникийн гэрчилгээнд бичигдсэн эзэмшигчийн нэр, авто тээврийн үндэсний төвийн цахим мэдээллэлийн санд бүртгэгдсэн мэдээллээр тус тус нотлогдоно.</i></p> <p><b>Тендерт оролцогчийн ирүүлсэн тендер нь ТШӨХ-ийн ТӨӨЗ 5.3 (в)-д заасан өгөгдөл, шаардлагыг хангаагүй, ирүүлэхээр заасан материалын бүрдэл дутуу бол уг тендерээс татгалзана.</b></p>
<p><b>ТӨӨЗ 5.3 (г)</b></p>	<p>Тендерт оролцогчийн ерөнхий инженер нь салбартаа 5-аас доошгүй жил ажилласан бөгөөд ажиллах хугацаандаа тендерт санал болгосон барилга угсралтын ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх гэрээг 3-аас доошгүй жил ажилласан мэдээллийг түүний мэргэжлийн диплом, иргэний үнэмлэхний хуулбарыг нотариатаар баталгаажуулан хамт ирүүлнэ.</p>

<p><b>ТӨӨЗ 5.3 (д)</b></p>	<p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн<sup>7</sup> нийт дүн: <b>Захиалагчаас санал болгож буй төсөвт өртгийн 30%-иас багагүй байх</b></p> <p><b>ТӨӨЗ 5.3 (д)-ын 1.</b> Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтийн аль нэгээр тодорхойлно. Үүнд:</p> <p>1.1. Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зөвхөн судлагдсан баталгаажсан зээлийн тодорхойлолт ирүүлнэ. /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой, тодорхойлолт гаргаснаар банк төлбөрийн хариуцлага хүлээхгүй гэсэн мэдэгдэл бүхий тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй/</p> <p>1.2. Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд.</p> <p><b>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах зээл нь ТШӨХ-ийн ТӨӨЗ 5.3 (д)-д заасан хэмжээ, өгөгдөл, шаардлагыг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана.</b></p>
<p><b>ТӨӨЗ 5.3 (е)</b></p>	<p>Тендерт оролцогч нь сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудад ашигтай ажилласан байх бөгөөд тус шаардлагыг хангаагүй нөхцөлд оролцогчийн тендерээс татгалзана.</p> <p><b>+Тендерт оролцогч нь ТШӨХ-ийн ТӨӨЗ-ны 5.3-ын (а)-(е) хүртлэх ирүүлэхээр заасан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн цахим хэлбэрт оруулж ирүүлэх ба ирүүлсэн бүх материалд тод, уншигдахуйц, бичиг хэргийн стандарт шаардлага хангасан байх шаардлагатай.</b></p> <p><b>Хэрэв тод биш, уншигдахааргүй тендерийн материал ирүүлсэн бол иж бүрдэл дутуу гэж үзэн тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</b></p>

<sup>7</sup> Авах боломжтой зээл гэдэгт зээлжих баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл зэрэг байж болно.

<p><b>ТӨӨЗ 6.1</b></p>	<p>Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:</p> <p><b>ТӨӨЗ 6.1-ын 1.</b> Түншлэлийн хувьд чадварын доод шалгуур буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр ТӨӨЗ 5.3 /а/, /б/ ба /д/-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг доод тал нь 25 хүртэл хувь, төлөөлөх эрх бүхий гишүүн (толгой компани) доод тал нь 40-аас доошгүй хувийг хангасан байх ба Иргэний хуулийн дагуу байгуулсан түншлэлийн гэрээтэй байна. Үүнд:</p> <p>1.1. Улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан байх/ 1.2. Тусгай зөвшөөрөл /нотариатаар баталгаажуулсан байх/</p> <p><b>ТӨӨЗ 6.1-ын 2.</b> “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлийг хангасан тухай материалыг ирүүлэх.</p> <p>2.1. Түншлэлээр оролцогч нь ТШӨХ-ийн ТӨӨЗ 5.2-т заасан нөхцөлийг хангасан байна.</p> <p>2.2. Түншлэгчийн хувьд тендерт оролцогчийн нэгэн ижил нөхцөл, шаардлагыг хангасан байх бөгөөд түншлэгчийн гүйцэтгэх ажлын төсвийг БНбаД дагуу тооцож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулж, холбогдох баримт бичгийг ирүүлсэн байна. Түншлэгч нь дээрх шаардлагыг хангаагүй мөн төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181-р тушаалаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу алдаагүй тооцож, Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох програмаар алдаагүй хийж гүйцэтгэсэн байх бөгөөд заасан нөхцөл шаардлагыг хангаагүй тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Анхааруулга: Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журмын 3.3.1-д “Тендерт оролцогч нь түншлэлээр оролцох бол талууд цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байх;” гэж заасны дагуу цахим системээр дамжуулан гэрээ байгуулаагүй тохиолдолд уг журмын 3.11-д “Тендерт оролцогч тендер илгээхдээ журмын 3.3.1-д зааснаар түншлэлийн бусад гишүүдтэй гэрээ байгуулаагүй бол хуулийн 5.1.6.б-д заасан тендерт оролцогч гэж үзэхгүй” гэж заасны дагуу түншлэлээр тендерт оролцсон гэж үзэхгүй болохыг анхаарна уу.</p> <p><b>ТШӨХ-ийн ТӨӨЗ 6.1-ын 1, 2-д болон бусад хэсэгт заасан өгөгдөл, анхааруулга шаардлагын аль нэгийг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана.</b></p>
<p align="center"><b>Б. Тендерийн баримт бичиг</b></p>	

<p><b>ТӨӨЗ 10.1</b></p>	<p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:</p> <p><b>[Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГазар, Төр захиргааны 2 дугаар давхарт.</b></p> <p><b>Утас: 7027-3579</b></p> <p>Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө захиалагчид бичгээр гаргаж болно. Тендерт оролцогч цахим тендерийн тодруулгатай танилцах үүрэгтэй.</p> <p>Тендерт оролцогч албан ёсны тодруулга авах нөхцөлд</p> <p style="text-align: center;"><a href="mailto:www.tuvprocurement@gmail.com">www.tuvprocurement@gmail.com</a> хаягруу ирүүлнэ.</p> <p><b>Анхаар!!!</b> Тодруулгыг Төрийн Худалдан Авах Ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> сайтын ТОДРУУЛГА буланд нийтлэх тул тендерт оролцогчийг тодруулга буланг байнга шалгахыг зөвлөж байна.</p> <p>Тендерийн тодруулгыг үзээгүй оролцогчийн өмнө захиалагч байгууллага хариуцлага хүлээхгүй болно.</p>
<p><b>ТӨӨЗ 11.1</b></p>	<p>Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг зохион байгуулах эсэх: <b>[“үгүй”]</b></p> <p>Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг зохион байгуулах газрын хаяг, хугацаа: <b>Өмнөх уулзалт зохион байгуулахгүй тул хаяг, хугацааг заахгүй</b></p> <p>Ажлын талбайтай танилцах ажиллагааг захиалагчаас зохион байгуулах огноо <b>[“зохион байгуулахгүй”]</b></p>
<p><b>В. Тендер бэлтгэх</b></p>	
<p><b>ТӨӨЗ 13.1</b></p>	<p>Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй бол тендерийн хэл нь Монгол хэлээс гадна дараах хэл дээр байна. Үүнд: <b>[Монгол хэл байна].</b></p> <p><b>Тендерт гадаадын этгээд оролцох эрхгүй.</b></p>
<p><b>ТӨӨЗ 14.1 (а)</b></p>	<p>Тендерийн маягыг тендерийн баримт бичиг заасан дагуу бэлтгэж ирүүлнэ.</p> <p>Анхааруулга: Тендерт оролцогч нь Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-тай танилцахыг зөвлөө. Уг журмын 3.3.2-т заасны дагуу илгээсэн тендерийн материалын агуулга нь системийн холбогдох талбарт оруулсан мэдээлэлтэй зөрвөл системийн талбарт бөглөсөн мэдээллийг баримтална.</p>
<p><b>ТӨӨЗ 14.1 (ж)</b></p>	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг захиалагчид хаяглан өөрийн тендерт ирүүлнэ.Үүнд:</p> <p><b>ТӨӨЗ 14.1 (ж)-ын 1.</b> Доорхи захиалагчийн хяналтын зардал, зураг төсвийн үнэ, зохиогчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын зардал, норм нормативын сан зэргийг тендерт оролцогч өөрийн төсөвт оруулж тусгана.</p> <p><b>Үүнд:</b></p> <p><b>-Захиалагчийн хяналтын зардал:</b> Зураг, төсвийг норм дүрмийн дагуу тооцож, санал болгож буй өртгийн төсөвт тусгаж ирүүлнэ.</p> <p><b>-Инженер хайгуул, зураг, төсвийн үнэ- 50,000,000 төгрөг</b></p> <p><b>Зохиогчийн хяналтын зардал:</b> Уг зардлыг зураг, төсвийн норм</p>

дүрмийн дагуу тооцож, санал болгож буй өртгийн төсөвт тооцож ирүүлнэ.

**-Магадлашгүй ажлын зардал:** Уг зардлыг зураг, төсвийн норм дүрмийн дагуу тооцож санал болгож буй өртгийн төсөвт тооцож ирүүлнэ.

**-Норм, нормативын сан:** Уг зардлыг зураг, төсвийн норм дүрмийн дагуу санал болгож буй төсөвт тооцож ирүүлнэ.

**Тендерт оролцогч нь дээр заасан захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн шимтгэл, магадлашгүй ажлын зардал зэргийг зураг, төсвийн норм дүрмийн дагуу тооцож, санал болгож буй төсөвтөө тусгаж ирүүлэх ба дээрх зардлыг тооцохдоо барилгын зураг төсөл зохиох норм дүрмийн дагуу тооцох хэмжээнээс багаар тооцож ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. **Барилгын төсөвт тусгагдсан материалыг ашиглах ба өнгөнд тавигдах код, стандартыг мөрдөнө.****

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 2.** Барилгын ажилд ашиглахаар санал болгож буй материал нь Монгол улсад болон олон улсад мөрдөгдөж байгаа стандарт хангасан болохыг нотлох техникийн тодорхойлолтыг бэлтгэж, холбогдох тайлбар үндэслэлийг тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж, төслийн менежерт ирүүлэх ба энэ нь гэрээний салшгүй хэсэг болно.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 3.** Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны графикийг /маягт №ТШМ-2-6 дагуу/ ирүүлнэ. Мөн аргачлалыг зургийн тайлбартай уялдуулан боловсруулж, талбай дээрхи нэгжийн бүтэц зохион байгуулалтын хамт ирүүлнэ.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 4.** Тендерийн баримт бичигт шинэчлэн хавсаргасан хяналтын зураг, ажлын тоо хэмжээг үндэслэн өөрийн ажлын төсөвт өртгийн тооцооллыг ирүүлэх /Захиалагчаас тендерт оролцогчдод хүргүүлсэн ажлын тоо хэмжээ нь ТЭЗҮ болон барилга угсралтын ажлын зурагтай зөрсөн тохиолдолд зургийг үндэслэж төсвөө тооцож ирүүлнэ/, /Шаардлагатай тохиолдолд захиалагчаас ажлын зураг, тоо хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан нөхцөлд цахим тендерийн тодруулгад нийтлэх тул ТӨӨЗ-ны 10.1-т заасны дагуу тодруулга буланг байнга шалгана уу./ ба хяналтын зургийн тоо хэмжээгээр тендерт оролцогчийн үнийн санал, материалын үнэ зэргийг зах зээлийн бодит үнэтэй хянаж үнэлнэ. Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон өртөгийн төсвийг, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна /төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181-р тушаалаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу алдаагүй тооцож, Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар алдаагүй хийж гүйцэтгэсэн байна.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 5.** Тендерт санал болгож буй үнийн дүн нь зураг, ажлын тоо хэмжээний дагуу боловсруулсан төсвийн дүнтэй ижил байна.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 6.** Үнийн саналыг Маягтын дагуу ирүүлнэ.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 7.** ТӨӨЗ-ийн 4.2.1-4.2.9-т заасан нөхцөл үүсээгүй мэдэгдэл

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 8.** Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын зураг, төсөв БНбаДүрмийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн бараа, ажил, үйлчилгээг дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 9.** Санхүүжилтийн хуваарийг маягт №ТШМ 2-2.7 маягтаар гаргаж, баталгаажуулан ирүүлнэ.

	<p><b>ТӨӨЗ 14.1 (ж)-ын 10.</b> Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</p> <p><b>ТӨӨЗ 14.1 (ж)-ын 11.</b> Тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн баримт бичиг, үнийн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзахгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдлийг бүрэн ирүүлнэ.</p> <p><b>ТӨӨЗ 14.1 (ж)-ын 12.</b> Барилга угсралтын болон их засвар, засварын ажилд шаардагдах үндсэн тоног төхөөрөмж, техник, багаж хэрэгслийг цаг хугацаанд нь бэлэн байлгах тухай мэдэгдэл ирүүлнэ.</p> <p><b>ТӨӨЗ 14.1 (ж)-ын 13.</b> Тендерт оролцогч нь ажлын талбай, түүний байршил, орчны нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж судлан тендер бэлтгэсэн талаарх албан мэдэгдлийг газар дээр нь танилцсан фото зургийн хамт ирүүлнэ.</p> <p><b>ТӨӨЗ 14.1 (ж)-ын 14.</b> Барилгын ажилд хэрэглэх импортын материал болон тоног төхөөрөмжийг Монгол Улсад үйлдвэрлэсэн материалаас тусад нь багцалж дараах хүснэгтээр ирүүлнэ. Үүнд:</p> <table border="1" data-bbox="472 680 1453 1025"> <thead> <tr> <th data-bbox="472 680 533 882">№</th> <th data-bbox="533 680 751 882">Барилгын материалын нэр, загвар, марк</th> <th data-bbox="751 680 1007 882">Барилгын материалын техникийн тодорхойлолт, холбогдох стандарт</th> <th data-bbox="1007 680 1118 882">Хэмж их нэгж</th> <th data-bbox="1118 680 1198 882">Тоо</th> <th data-bbox="1198 680 1310 882">Нэгж үнэ /төгрөг/</th> <th data-bbox="1310 680 1453 882">Бүгд үнэ /төгрөг/</th> </tr> <tr> <th data-bbox="472 882 533 916">1</th> <th data-bbox="533 882 751 916">2</th> <th data-bbox="751 882 1007 916">3</th> <th data-bbox="1007 882 1118 916">4</th> <th data-bbox="1118 882 1198 916">5</th> <th data-bbox="1198 882 1310 916">6</th> <th data-bbox="1310 882 1453 916">7</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="472 916 533 949"></td> <td data-bbox="533 916 751 949"></td> <td data-bbox="751 916 1007 949"></td> <td data-bbox="1007 916 1118 949"></td> <td data-bbox="1118 916 1198 949"></td> <td data-bbox="1198 916 1310 949"></td> <td data-bbox="1310 916 1453 949"></td> </tr> <tr> <td data-bbox="472 949 533 983"></td> <td data-bbox="533 949 751 983"></td> <td data-bbox="751 949 1007 983"></td> <td data-bbox="1007 949 1118 983"></td> <td data-bbox="1118 949 1198 983"></td> <td data-bbox="1198 949 1310 983"></td> <td data-bbox="1310 949 1453 983"></td> </tr> <tr> <td colspan="7" data-bbox="472 983 1453 1025" style="text-align: center;"><b>Нийт үнэ /төгрөг/</b></td> </tr> </tbody> </table> <p><b>ТШӨХ-ийн ТӨӨЗ 14.1 (ж)-д заасан өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй, ирүүлэхээр заасан баримт материалын бүрдэл дутуу, шаардлагын хэмжээнд боловсруулагдаагүй, буруу тооцогдож ирсэн бол тухайн тендерээс татгалзана.</b></p>	№	Барилгын материалын нэр, загвар, марк	Барилгын материалын техникийн тодорхойлолт, холбогдох стандарт	Хэмж их нэгж	Тоо	Нэгж үнэ /төгрөг/	Бүгд үнэ /төгрөг/	1	2	3	4	5	6	7															<b>Нийт үнэ /төгрөг/</b>						
№	Барилгын материалын нэр, загвар, марк	Барилгын материалын техникийн тодорхойлолт, холбогдох стандарт	Хэмж их нэгж	Тоо	Нэгж үнэ /төгрөг/	Бүгд үнэ /төгрөг/																														
1	2	3	4	5	6	7																														
<b>Нийт үнэ /төгрөг/</b>																																				
<b>ТӨӨЗ 16.1</b>	Хувилбарт тендер ирүүлэхийг <b>["зөвшөөрөхгүй"]</b> .																																			
<b>ТӨӨЗ 17.8</b>	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>["тохируулахгүй тогтмол байна."]</b>																																			
<b>ТӨӨЗ 18.1</b>	Тендерийн валют: <b>[Төгрөг байна.]</b>																																			
<b>ТӨӨЗ 20.1</b>	Тендер нээснээс хойш <b>30</b> хоногийн туршид хүчинтэй байна.																																			
<b>ТӨӨЗ 21</b>	<p>Тендерийн баталгааны үнийн дүн:</p> <p><b>Тендерийн хамт 23 920 000 (Хорин гурван сая есөн зуун хорин мянган) төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.</b></p> <p>Баталгааны хүчинтэй байх хугацаа: <b>2020 оны 7 сарын 18-ны өдрийг дуустал хүчинтэй байна.</b> Тендерт оролцогч цахим тендерийн баталгаа гаргагч арилжааны банкаар цахим баталгаа ирүүлэх бөгөөд арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.</p> <p>Дараах тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгоно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>Тендерт оролцогч тендерийг нээсний дараа тендерийн хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс татгалзсан. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.1 дэх заалт.</li> <li>"хамгийн сайн" үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ</li> </ol>																																			

	байгуулах эрх олгосон мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.2 дэх заалт
<b>ТӨӨЗ 22.4</b>	Тендерт оролцогч тендерийн материалд “Хувь хүний нууцын тухай” болон “Байгууллагын нууцын тухай хууль”-иудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна.
	<b>Г. Тендер ирүүлэх</b>
<b>ТӨӨЗ 23.3 (б)</b>	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь:</p> <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн цахим хэлбэрт оруулж ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, уншигдахуйц, бичиг хэргийн стандарт шаардлага хангасан байх шаардлагатай.</p> <p>Хэрэв тод биш, уншигдахааргүй тендерийн материал ирүүлсэн бол иж бүрдэл дутуу гэж үзэн тухайн тендерээс татгалзах үндэслэл болно</p> <p>Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) –д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Байгууллагын хаяг: <b>Төв аймаг, Зуунмод сум, 6-р баг, “Төр захиргааны 2 дугаар байр”, ОНӨГХАААлба.</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба, өрөөний дугаар 201 тоот.</b></p> <p>Аймаг, хот: <b>Төв аймаг Зуунмод хот</b></p> <p>Улс: <b>“Монгол Улс”</b></p>
<b>ТӨӨЗ 23.3 (в)</b>	<p>Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: <b>[ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН БАРИЛГЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ]</b></p> <p><b>ТШДугаар: ТӨАОНӨГ/202004091</b></p> <p>Тендерт оролцогч тендерийн хуудас бүрийг дугаарлаж, гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулж ирүүлэх.</p> <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ форматад хөрвүүлэн, өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр цахим хэлбэрээр ирүүлнэ. <b>Тендерт оролцогчийн цахим системээр ирүүлж оролцсон ТӨӨЗ болон ТШӨХ-д заасан тендерийн баримт бичгийг бэлтгэн ирүүлсэн тендерийн материал нь тендерт оролцогчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн нууц үгтэй улмаас нээгдэхгүй /Adobe PDF/ форматад хөрвүүлсэн файл уншигдахгүй /тод гаргацтай байна/ тохиолдолд үнэлгээнд харгалзан үзэхгүй татгалзах үндэслэл болно,,,</b></p>
<b>ТӨӨЗ 24.1</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2020 оны 05 дугаар сарын 21-ний өдөр</b></p>

Цаг: 11 цаг 00 минут

**Д. Тендерийг нээх, үнэлэх**

**ТӨӨЗ 27.1**

Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:  
Байшин, гудамжны нэр: **Төв аймаг, Зуунмод хот, 1-р баг, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв,**  
Давхар болон өрөөний дугаар: **1 дүгээр давхарт, Цахим тендерийн нээлтийн өрөө**  
Аймаг, хот:Төв аймаг, Зуунмод хот  
Улс:“**Монгол Улс**”  
